

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮЙЛ ЯВЦ

Б.БАЛДОО*

Бүс нутгийн үндсэн дээр явагдаж байгаа интеграцийн буюу интеграцийн шинжтэй нэгдэх үйл явцууд орчин үеийн нийгмийн эдийн засаг болон улс төрийн амьдралд нэлээд их бөгөөд чухал байр суурь эзлэх болж, тэдгээр нь дэлхий нийтийн болон бүс нутгуудын аж ахуйн үйл ажиллагаа, нийгэм-улс төрийн дэвшил хөгжилд үлэмжхэн хувь нэмэр оруулах болжээ.

Улс орнуудын эдийн засагт интернационалчлал /үндэсний ба дэлхийн аж ахуйнуудын харилцан холбоо, харилцан хамааралын өсөлт/ ба регионалчилалын /нэгэн бүс нутагт орж буй улсуудын хоорондох эдийн засаг, улс төрийн хэлхээ холбооны хөгжил, бэхжил/ тодорхой хоёр хандлага буй болон параллелиар /зэрэгцэн/ явагдаж байна. Тэгэхдээ регионалчлалын үйл явц нь орчин үед тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна. Регионалчлал гэдэг ойлголтод бүс нутгийн эдийн засгийн бүлэглэлүүд болон бүс нутгийн эдийн засгийн интеграцийн үйл явц багтан ордог аж.

Бүс нутгийн эдийн засгийн бүлэглэлүүд дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө үүссэн ч дайны дараа үеэс тодорхой дүрс төлөвийг олж, үйл ажиллагаа нь тод болж иржээ.

Дэлхийн өнгөрсөн зууны сүүлчийн арав гаруй жилд Европын холбоо, Умард Америкийн чөлөөт худалдааны бүс, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны форум хэмээх олон талын интеграцийг хэрэгжүүлдэг бүхэл бүтэн тивүүдийг хамаарсан байгууллагуудаар төлөөлүүлсэн эдийн засгийн гурван том бүлэглэл үйл ажиллагаагаа явуулж байна. Европын хамтын нийгэмлэг 1993 онд европын нэгдсэн зах зээлийг байгуулан дуусгаж, Умард Америкийн гурван улс нийлэн 1994 оны эхнээс чөлөөт худалдааны бүхэл бүтэн бүс болж, Номхон далайн дорнод, өрнөд эрэгт гарцтай бараг бүх улс 1989 онд Ази-Номхон далайн эдийн засгийн нэгдэл байгуулж олон жилийн эрэл хайгуул, цөхрөлтгүй зүтгэл нь үр дүнгээ өгч эхлэв. Эдүгээ аж үйлдвэр хөгжсөн олонх орон бүс нутгийн дотооддоо эдийн засгийн бараг саад хориггүй нэн том бүлэглэлүүдийн бүрэлдүүнд ойрын ирээдүйд

*Б.Балдоо - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич

орно. Европын зөвлөл эдийн засгийн интеграцийг шинэ үндсэн дээр өндөр түвшинд хэрэгжүүлж чадсанаар нийтэд үлгэр загвар гаргасныг бусад тивийн бүлэглэл байгууллагууд тэдний дотор Ази, Номхон далайнхан судлан туршиж үзэх хэрэглэгдэхүүнийг буй болгожээ.

Өнгөрсөн гурван арван жилийн туршид Ази, Номхон далайн орнуудын эрдэм шинжилгээ, бизнес, улс төрийн хүрээнийхэн дотор Европын хамтын нийгэмлэг мэт бүтцийг Номхон далайн орнуудын дунд байгуулах талаар өргөн ярилцан хэлэлцэж, бичиж байлаа. Гэвч бие биетэйгээ хиллэсэн хуурай газрын нутаг дэвсгэртэй, эдийн засгийн хөгжил болон соёлын үзүүлэлтийн түвшингээр ерөнхийдөө нэг төрлийн цогц бүрэлдхүүнтэй улсууд оршдог Өрнөд Европтой зэрэгцүүлбэл Номхон далайн сав газар нь асар уудам газар зүйн, тэгэхдээ голдуу далай усны орон зайг хамаардагийн дээр энэ далай усны орон зайн эргээр эдийн засгийн үзүүлэлтүүдээр ч гэсэн, соёл-түүх, шашин, үндэс язгуур, бусад зүйлээр ч гэсэн хоорондоо ижилсэх зүйлээр тун ч бага улс орнууд оршдог. Иймээс эдгээр улсуудыг улс төрийн биш юмаа гэхэд эдийн засгийн сонирхлоор нь холбон ойртуулах үндсэн дээр нэгтгэх, интеграцчилах үзэл санаа удаан хугацаанд бодит байдлаар хэрэгжиж чадалгүй явсан байна.

Тэгэхдээ энэ том бүс нутгийн улс орнуудын хооронд эдийн засгийн харилцан үйлдэл хийгдэж байв. Тэр нь голдуу хоёр талын үндсэн дээр явагдаж байсан аж. Эдийн засгийн энэхүү үйлдлээ илүү үр дүнтэй болгох үүднээс тэндэх улс орнууд бүс нутгийн бүлэглэлүүдийг байгуулж эхэлсэн байна. АГПР /АНДБн/-ийн хүрээнд ийм бүлэглэлүүд 80-аад оноос бүрдэж ажиллан эхэлжээ. Эдгээр нь голдуу хил нийлсэн улсуудын эдийн засгийн сонирхол илэрхийлсэн улс төрийн бус холбоонууд, хэд хэдэн улс орон ба нутаг дэвсгэрийн эдийн засгийн сонирхлын хүрээнд оршиж байдаг худалдааны хаалттай бүлэглэлүүд /бүс/ байв. Гол нь эд харилцан худалдаа хийхдээ оролцогч улс, нутаг дэвсгэртээ эдийн засгийн тодорхой давуу талыг олгодог байжээ.

Ийм бүлэглэлүүдийг бүрдүүлэхдээ худалдааны чөлөөт бүсүүд байгуулдаг байсан бөгөөд эдгээр чөлөөт бүсүүдийг GATT/WTO /Дэлхийн худалдааны байгууллага/-ийн дүрмээр бүлэглэлд тооцдог байв. Дэлхийн худалдааны байгууллагийн дүрмийн заалт, бусад тогтоомжууд АГПР-т чөлөөт бүсүүд байгуулахад зохих үүрэг гүйцэтгэжээ. Яваандаа 90-ээд оны дунд хүрч ирэхэд АПЕК /АНд Эд Ха/-ын районд улс дундын худалдааны тохиролцоо буюу холбоонууд үүсэн ажиллах болсны дотор том нь Хойд Америкийн чөлөөт худалдааны бүс байгуулах тухай хэлэлцээр /НАФТА/, АСЕАН-ы чөлөөт худалдааны бүс байгуулах тухай

хэлэлцээр /АФТА/ бөгөөд мөн АПЕК-ийн зарим гишүүдийн хооронд байгуулсан хоёр талын ба олон талын нэлээд хэлэлцээрүүд байсныг Ази-Номхон далайн бүс нутгийн худалдааны бүлэглэлүүдэд хамааруулан тооцдог ажээ.

Анх АПЕК-ийн зарим гишүүд хоёр ба хэд хэдэн талын хэлэлцээр байгуулахаар тохиролцож түүнээ нэрлэх хэлбэрээ сонгохдоо “өсөлтийн гурвалжин” гэсэн томъёололыг хэрэглэсэн нь оновчтой болж энэ нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийн үг хэллэгт оржээ. Энэ томъёололоор хоёр буюу хэд хэдэн улс хилийн уулзварт орших район нутгийг ойлгох бөгөөд бүс нутгийн хэмжээнд хэрэгцээтэй байгаа буюу хэрэгцээ олох тодорхой хэмжээний бараа таваарыг болон үйлчилгээг эдгээр улс дотооддоо үйлдвэрлэхэд таатай нөхцөлтэй, эсвэл түүнийг бий болгодог байна. “Өсөлтийн гурвалжины” зармыг засгийн газрууд нь, бусад хэсгийг нь хувийн бизнесийн санаачилгаар байгуулдаг байна. Энэ үйл явц нь эдгээр улс бие биеэ эдийн засгийн талаар харилцан нөхөх бололцоо, газар зүйн ойр дөт байдал, улс төрийн ижил төстэй сонирхол, хамтдаа дэд бүтцийг хөгжүүлэхийн төлөө тавьж буй анхаарал сонирхол мэт бодит зүйлээр нөхцөлдсөн учраас амжилтад хүрч чаддаг байна.

Энэ бол хоёр талын харилцааны зэрэгцээ улс улсын орон нутгуудын хооронд олон талын хөтөлбөр үүсэн хэрэгжиж буйн илрэл юм. Энэ үйл явцыг проф.Р.Скалапино чухалчилан үзэж түүнтэй холбогдуулан “natural economic territories” /NET/ /байгалийн эдийн засгийн нутаг дэвсгэр/ гэдэг ойлголтыг нэвтрүүлж, тэдгээр нутгийн тоонд улс төрийн хил хязгаар дамнасан эдийн засгийн нутаг дэвсгэрийг оруулжээ. Энэ нь бүс нутгийн янз бүрийн орнуудын эдийн засгийн давуу талыг бодит зүйл болгох бололцоо олгодог байна.¹

“Өсөлтийн гурвалжин” эдийн засгийн вертикал /босоо/ интеграцийг хөгжүүлэхэд түлхэц үзүүлдэг юм. 90-ээд оны хоёрдугаар хагаст Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутагт нэрд гарсан гурван “өсөлтийн гурвалжин” хэлбэржин эмхэрсэн гэж судлаачид тэмдэглэх нь бий. Энэ гурван гурвалжины хүрээнд бүс нутгийн хоёр юм уу, түүнээс илүү улс орон, нутаг дэвсгэрүүдийн эдийн засгийн сонирхол харилцан үйлдэлд орсон байна.

Тэдгээр нь: - Австрали-Шинэ Зеландийн хоорондын эдийн засгийн улам нягт харилцааны тухай хэлэлцээр, - Өмнөд Хятад-Гонконг ба Хятад-Тайваний “өсөлтийн бүс”, - Индонез-Малайз-Сингапурын “хөгжлийн гурвалжин” юм. Дурдаж буй гурвалжингуудын дотор үлгэр загвар болсон анхных нь 80 оны сүүлч хавиар үүссэн Сингапур-Жохор

/Малайз/ -Батам /Индонез/-ын гурвалжин юм. Энэхүү гурвалжины хүрээн дотор Сингапурын өндөр технологи, Малайзийн дунд түвшний техник, Индонезийн аж үйлдвэрийн хөдөлмөр зэрэг хослон шингэсэн аж ахуйн салбарууд хөгжсөн байна.

Эдгээрээс гадна АПЕК-ийн гишүүдийн хоорондох хоёр талын тохиролцооны тоонд Чили, Мексикийн хоорондох чөлөөт худалдааны тухай хэлэлцээр; Канад, Чилийн хоорондох чөлөөт худалдааны тухай хэлэлцээр тус тус орно. АПЕК-ийн гишүүдийн худалдаа-эдийн засгийн харилцаанд МЕРКОСУР, Андийн пакт /гэрээ/, Карибийн нийтийн зах зээл, Төв Америкийн нийтийн зах зээл зэрэг бусад дэд бүс нутгийн худалдааны бүлэглэлүүд шууд холбогдолтой гэж үздэг байна.²

Дурдсан бүлэглэлүүд цөм АПЕК-ийн газар зүйн орон зайд дотор үйлчилдэг, гэхдээ АПЕК-тай эрх зүйн хэлэлцээрийн холбоогүй. Форумын зарим гишүүд оролцдог худалдаа-эдийн засгийн бүлэглэлүүд АПЕК-ийн бүс нутагт байгаа нь бодит үйл явц бөгөөд тэд үүнийг цааш хөгжүүлэх сонирхолтой байдаг ажээ.

Монголын хувьд гэвэл тус улс эдгээр тохиролцоог санаачлан үүсгэж хэрэгжүүлсэн улс орнуудаас хол зайдуу байдаг билээ. Харин Скалапиногийн дэвшүүлсэн “байгалийн эдийн засгийн нутаг дэвсгэр” гэдэг ойлголтын үзэл санааг судлан авч хэрэгжүүлэх талаар бодож сэтгэх, ялангуяа ЗӨА-ийн буюу өөр бусад орны бий болгосон “хөгжлийн буюу өсөлтийн гурвалжин” хэмээх үр ашигаа өгч буй хэлбэрийг ашиглаж болмоор юм. Үүний тул Умард, Өмнөд хоёр хөрштэйгээ хил нийлсэн районуудаас “өсөлтийн гурвалжин” нутаг дэвсгэрийг сонгон авч хамтарсан интеграцийн үйл ажиллагаа өрнүүлж болох биз. Энэ туршилт хийхийн тулд дотооддоо олон талын шуурхай судалгаа хийж, улс төрийн хүсэл зориг гарган шийдэж, асуудлыг тодорхой болгоод хоёр хөрштэйгээ ярилцан тохиролцож амьд ажил болгож чадвал Монгол орны АПЕК-д элсэх чиглэлд явуулах урьдач бэлтгэл, интеграцчилах үйл явцад нэн хэрэгтэй юм.

Ази, Номхон далайн бүс нутаг дахь эдийн засгийн бүлэглэлүүдийн хэлбэрт тооцогддог худалдаа эдийн засгийн чөлөөт бүсүүд байгуулагдах үйл явц 80-аад, 90-ээд онд өргөжив. Чөлөөт бүсүүдэд бий болгодог дүрэм журмууд нь тэрхүү улсын бусад нутгуудад үйлчилдгээс өөрөөр тогтоогддог тэдгээрийн онцлог оршдог билээ. Энэ ялгаа нь гаалийн ба ашиг орлогын татварын доогуур хэмжээ, хөлсний хөдөлмөрийг чөлөөтэй ашиглах бололцоо, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан тусгай нөхцөл гэх мэтэд илрэлээ олдог юм.

Бөмбөрцөгийн дорнод хэсгийн Гонконг, Сингапур, Тайваньд

үүссэн чөлөөт бүсүүд АПЕК дахь анхны чөлөөт бүсүүд байлаа. 80-аад онд Зүүн өмнөд Азид чөлөөт бүс байгуулах бум буюу өрнөл гэгч явагдав. 80-90-ээд оны зааг дээр Хятад, Умард Солонгос, Орост түрүүчийн бүсүүд байгуулагджээ. Томоохон усан боомт, зам харилцааны уулзуурт оршдог хот, голын хөндий гэх мэт тодорхой объектуудыг чөлөөт бүс болгохын хамт бүхэл бүтэн район нутгийг ийм бүс болгох болжээ.

Бүс нутгийн улс, нутаг дэвсгэрүүдийн эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй чөлөөт бүсүүдэд юуны өмнө гадаадын хөрөнгийг оруулах жинхэнэ бололцоо нээгддэг. Үүний ачаар АНДБН-н орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт хүчтэй явагджээ. Авч үзэн буй бүс нутгийн гадаадын хөрөнгө оруулалтын тухай ярихад Япон, АНУ хоёр гүрний хувь нэмрийг онцлох ёстой бөгөөд тэдний хөрөнгө оруулалт нь динамик өсч, бүсийн улсуудын эдийн засгийн өсөлтөд дорвитой хүчин зүйл болж, бүс нутгийн олон улсын хөдөлмөрийн хувиар бүрэлдэхэд ихэд нөлөөлж байгаа болно. АНУ ба Япон капиталын хувь нь Дорнод Азийн орнуудын оруулсан нийт хөрөнгө оруулалтын 45 хувийг эзэлж байсан бөгөөд 80-аад оны эцсээр АНУ, Японы шууд оруулсан хөрөнгө бүхэлдээ 32 млрд. доллараар үнэлэгдэж байв.³ Сүүлийн үед шинээр үйлдвэржсэн орнууд АСЕАН-ы гишүүн орнуудын томоохон хөрөнгө оруулагч болсны дээр Хятад ч мөн ийм байр суурьд шилжих боллоо.

Дашрамд тэмдэглэхэд аж үйлдвэр хөгжсөн орнуудад ажиллах хүч дутагдалтай, ажлын хөлс өндөр, газрын түрээсний үнэ нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд хөгжилтэй орнууд капиталаа гадагш гаргах явц дунд бүхэл бүтэн үйлдвэрлэлийг буурай орон руу гаргах болжээ. Үүний явцад бүс нутгийн хөгжилтэй ба хөгжиж байгаа орнуудын хооронд бүсийн эдийн засгийн харилцан хамаарлын бүтэц эмхрэн бүрэлдэж буй бөгөөд тэр нь хөгжилтэй орнуудад ашигтай, ил тод симметрик биш бүтэц болон тогтох хандлагатай байгаа билээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнууд бүс нутагтаа интеграцчилах ажлын тодорхой замыг туулжээ. Тэдгээр орны интеграцийг сонирхсон янз бүрийн шинжийн, элдэв түвшний байгууллагууд, тэдний төлөөлөгчид, үндсэндээ эдийн засгийн байгууллагууд, эдийн засагчид хоёр тал ба олон талаар хамтран ажиллаж, интеграцийн арга хэмжээнүүд санаачлан төлөвлөн хэрэгжүүлж, хоршсон хамтын ажиллагааныхаа туршилтыг хуримтлуулж аажим хувьслын урсгал хөгжлийн замаар явжээ. Энэ явцад интеграцчлах үйл явцыг зохицуулах, хамтран төлөвлөж хэрэгжүүлэх хэрэгцээ гарч байсныг анхааран ухамсарлаж байв.

Хөгжлийн тодорхой үе буюу 80-аад оны төгсгөл рүү бүс нутгийн

интеграцлах ажлыг шинэ шатнаа гаргах урьдач нөхцөл бүрдсэн байв. Энэ нь интеграцийн үл явцыг институтчилэн, засгийн газрын түвшний болгох, нийт бүс нутаг ба дэд бүсийн байгууллагуудыг байгуулахад хүргэв.

Цаг мөчийн тулгалт шаардлага, бүс нутгийн улсын элитүүдийн хүсэл зоригийг тусган илэрхийлсэн Номхон далайн орнуудын гадаад хэрэг, худалдаа ба аж үйлдвэрийн сайд нар Канберра хотноо 1989 оны 11-р сард цугларч бүс нутгийн эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны байгууллагыг Австралийн ерөнхий сайд Б.Хоукийн саналаар үндэслэн байгуулжээ. Байгууллагыг Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа “Asian-Pacific Economic Cooperation” /АПЕК/ гэж нэрлэн түүний бага хурал буюу форумыг тогтмол хуралдуулж байх болжээ. Энд тэмдэглэхэд бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх үүднээс 17 орны үндэсний хороод оролцсон Номхон далайн эдийн засгийн зөвлөл “Pacific Economic Council” /ПЕК/-ийг Гонконгд төвлөрүүлэн 1967 онд, Бүс нутгийн худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаанд тус дэм үзүүлэх үүднээс 34 орон оролцсон Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл “Pacific Economic Cooperation Council” /ПЕСС/-ийг Сингапурт төвлөрүүлэн 1980 онд тус тус байгуулсан юм.

Шинэ байгууллагыг үндэслэх бага хуралд Австрали, Бруней, Канад, Индонез, Япон, Малайз, Шинэ Зеланд, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Тайланд, АНУ зэрэг 12 улс оролцсон бөгөөд дараагийн жилүүдэд тус байгууллагад Хятад, Гонконг, Тайвань, Мексик, Чили, Папуа-Шинэ Гвиней, Вьетнам, Перу, Орос улсууд нэгдэн нийлж одоо 21 улсын бүрэлдүүнтэй байна.

АПЕК-ийн бага хурал нь анхандаа хуралд оролцогсдын нийтлэг сонирхлыг татсан эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар зөвлөлдөн ярилцах газар байв. Цаашдаа энэ нь АПР дахь чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаанд дэм тус үзүүлэх тэргүүлэх бүтэц буюу байгууллага болон хувирч, бас бага хурлын статус нь сайд нарын түвшингээс дээшилж дээд түвшний болсон аж.

АПЕК-ийн бага хурлуудаар хэлэлцэж тогтсон гол асуудлуудаас товч дурдвал.

Нэгдүгээр бага хурлаар тус байгууллага нь ямар шинж төлвийн байгууллага байх вэ гэдгийг тодорхойлж, тэр нь эдийн засгийн эксклюзив /хаалттай, тусгай/ эвсэл болохгүй, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага байна, түүнд бүсээс гаднах улс

нэгдэхэд чөлөөтэй гэдгийг заав.

Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий зорилт бол худалдааны нээлттэй системийг хөгжүүлэх явдал болохыг хоёрдугаар бага хурлаар тодорхойлж, АПЕК-ийн Сайд нар GATT-худалдааны тарифийн байгууллагын Урагвайн раунд /хэлэлцээний/-ын хүрээнд хэлэлцээ хийж байхыг хатуу сахина гэж мэдэгджээ.

АПЕК-ийн Байнгын нарийн бичгийн дарга нарын газрыг 1992 онд дөрөвдүгээр хурлаар байгуулан, Сингапурт төвлөрүүлж, ажлын хэсгүүдийг хоёр ба гуравдугаар бага хурлаар байгуулж, төсвийг баталжээ. Мөн түүнчлэн гарамгай хүмүүсийн хэсгийг байгуулж бэлтгэсэн илтгэлүүдийг нь хэлэлцэж байсан боловч удалгүй тараажээ.

АПЕК өөрийн анхны Тунхаглалыг 1991 онд Сеулийн уулзалтаар гаргаж, түүнд форумын гол зорилт бол АПР-ийн эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар дэлхийн аж ахуйн хөгжилд хувь нэмэр оруулах явдал гэж заав.

АПЕК—ийн форум дөрөвдүгээр бага хурлыг дуустал Сайд нарын түвшинд хуралдаж байгаад америкчуудын санаачилгаар 1993 оны Сиэтлийн бага хурлаас сайд нарын зэрэгцээ улс орнуудын төрийн тэргүүн нарыг оролцуулах болгожээ.

Зургаадугаар уулзалтын /1994, Богор, Индониз/ үеэр худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчилах хүрээг тодорхойлсон хоёрдахь Тунхаглалаа гаргав. Түүнд: бүс нутгийн аж үйлдвэр хөгжсөн орнуудад 2010 оны янар, хөгжиж буй орнуудад 2020 оны янар чөлөөтэй бөгөөд нээлттэй худалдааг эмхлэн байгуулах, хөрөнгө оруулалтыг хориггүй нэвтрүүлэх талаар гишүүн орнуудын удирдагчид тохиролцоонд хүрчээ. Тунхаглалын энэ заалтын үндсэн дээр АПЕК нь цаашдаа худалдаа хөрөнгө оруулалтын чөлөөт бүс болох юм. Энэхүү Тунхаглалын утга санаанд интеграцийн чанд хатуу ба алгуур зөөлөн хоёр загварын дундуурах компромисс томьёолол, энэ байгууллагын Дорнод Азийн гишүүдийн баримтлалын тусгал ажиглагдах аж. Энд зах зээлийн хууль дагуу гүйцэлдэж буй интеграцийн үйл явцыг нарийн чанд институтчилэх шаардлагын үндэслэл тусгалаа үл олж, тэр нь бүс нутагт худалдаа хөрөнгө оруулалтын тогтвортой хөгжлийг хангагч аажим зөөлөн либералчлал хангалттай гэсэн үзлийг хүлээн зөвшөөрсөн хэрэг гэлтэй.⁴

АПЕК-ийн дараачийн бага хурлууд Богорын Тунхаглалын заалтуудыг нарийсган тодотгох, гишүүн орнуудын энэ чиглэлийн бодит ажиллагааны механизм, хөтөлбөрийг боловсруулан гаргах мэтэд чиглэгдсэн байна. 1996 онд Филиппинд болсон дээд уулзалтаар АПЕК-

т зориулсан үйл ажиллагааны Манилын төлөвлөгөөг гаргав. Тэр төлөвлөгөө нь АПЕК-ийн 18 гишүүний толилуулсан худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчлах “ганцаарчилсан үйлдлийн төлөвлөгөөнүүд”, либералчлалын талаар гишүүд хамтын хүчээр авах арга хэмжээнүүдийг багтаасан “хамтын үйлдлийн төлөвлөгөө” болон эдийн засгийн ба техникийн хамтын ажиллагааны салбар дахь хамтын үйл ажиллагаа гэсэн гурван хэсгээс бүрдсэн аж. Үүнээс үзвэл АПЕК-т гишүүн болон элссэн улс бүр өөрийн оронд хэрэгжүүлэх либералчлалын “ганцаарчилсан” төлөвлөгөө гаргаж, түүнээ биелүүлдэг, мөн “хамтын” төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцдог гэх мэт үүрэг хүлээдэг байна.⁵

Мэдээллийн технологийн саммит гэж дуудагдсан АПЕК-ийн наймдугаар уулзалт 2000 оны 11-р сард Брунейд болов. Лидерүүдийн гаргасан Тунхаглалд форумын хүн амын амьдралын түвшинг сайжруулах боломж нээж буй глобалчлалын амжилт ололт нь АПЕК-н хүрээнд боловсруулж буй эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн ачаар түүнд оролцогч улс бүрд хүртээмжтэй болохыг заав. Тунхаглалд Интернетийн сэдвийг чухалчлан үзээд АПЕК-ийн гишүүдийн дунд түүнийг ашиглагчдын тоог 2005 онд 3 дахин нэмэгдүүлж, хот хөдөөгийн хамтлаг нийгэмлэгүүдийг 2010 онд түүнийг хамтран ашиглагчид болгох зорилт тавив. АПЕК-т электрон худалдааг дэлгэрүүлэхийг сайшаахын хамт мэдээлэл, холбоо харилцааны технологи нь “шинэ эдийн засгийг” хөгжүүлэхэд түлхэц өгч, залуучуудыг сургах үндэс болно гэж Тунхаглалд тэмдэглэв.⁶

Ийнхүү АПЕК-ийн урагштай явц нь юуг харуулна вэ гэвэл сүүлийн жилүүдэд АПЕК дэх худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа нь улам итгэлтэй хүч авч байгааг, энэ хамтын ажиллагаа нь форумын улсуудыг интеграцийн нэгдсэн хүрээн дотор ойртуулсаар байгааг илтгэн үзүүлнэ.

Өнөөдөр Ази, Номхон далайн орнууд эдийн засгаа амжилттай хөгжүүлж, энэ бүс нутаг нь эдийн засгийн өсөлтөөр бусад бүс нутгийг давамгайлж, улмаар дэлхийн эдийн засгийн хөгжлийн нэг төв болж байна. АПР дэлхийн үйлдвэрлэлийн 60 орчим хувийг гаргаж, түүнд гадаад худалдааны нийт эргэлтийн 40 хувь нь оногдох боллоо. Хэрэв 1970-аад оны үед Ази, Номхон далайн орнуудын гадаад худалдаа европ болон бусад бүс нутгийн орнуудад үндсэндээ чиглэгдэж байсан бол одоо бүс нутгийн орнуудын гадаад худалдаа нь бүс дотроо өөр хоорондоо хийх худалдаанд давуутай шилжиж, түүний өсөлт дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс 20 дахин их боллоо.⁷

Ази, Номхон далайн улс орнуудын эдийн засгийн интеграцийн үйл явц амжилттай урагшлах тутам энэ нь бүсийн улс орнуудын

хоорондын итгэлцлийг улам нэмэгдүүлэн, аюулгүй байдлыг нь хангах асуудалтай улам нягт холбогдох болжээ. Хүйтэн дайн дууссанаас хойш хурцаар тавигдаж байсан энэ асуудал удаан хугацаанд янз бүрийн төвшинд хэлэлцэгдэн засгийн газруудын санаа бодлыг татсаар ирсэн юм.

1994 оны 7-р сард АСЕАН-ы орнуудын сайд нарын бага хурлаар АСЕАН-ы бүсийн форум /ARF/ байгуулжээ. Энэхүү форумын бүтцийг бий болгон бүрэлдүүлсэн нь Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын харилцааны шинэ шатны эхлэл болсон байна. Энэ үйл явдал нь аюулгүй байдлын салбарт олон талын хамтын ажиллагааг тодорхой хэмжээгээр институтчилэх гэсэн өсөн нэмэгдэж байгаа эрмэлзлэлийн тусгал, АПР-ын орнуудын өмнө тавигдсан “тогтвортой байдлын дуудлагыг” зөвлөлдөн ярилцах, сөргөлдөөний биш олон талын байнга ажиллах хамтын механизмын хүрээнд хүчин чармайлтаа нэгтгэсэн тохиолдолд амжилттай шийдвэрлэж болно гэсэн бодит үнэнийг бүс нутгийн элитүүд /удирдагчид/ ойлгон таньсны нотолгоо юм. Энэ утгаар авч үзвэл АРФ үүссэн явдал нь хоёрдугаар дайн дууссаны дараах АПР-ийн доторхи олон талын харилцааны хувьсал өөрчлөлтийн анхны дорвитой шат гэж болно. Энэхүү шинэ бүтэц бий болсон нь засгийн газруудын хооронд олон талын яриа хэлцэлийн механизм АПЕК-Т хэрэгтэй юу, үгүй юу гэсэн олон жилийн мэтгэлцээнийг эцэс болгов.

Бүс нутгийн форум нь эдийн засаг, нийгмийн талуудыг багтаасан бүс нутгийн аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах зорилт тавьсан байна. АРФ-ын үйл ажиллагааны үзэл баримтлал нь 1995 оны 8-р сард зөвшөөрөгдсөн. Энэ баримт бичигт форумын гишүүдийн өмнө тавигдаж буй зорилтуудыг шийдвэрлэхдээ “эволюцийн хандлагыг” баримтлахыг заагаад АРФ-ын зорилт нь “Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван байдал, цэцэглэл, тогтвортой байдлыг ханган дэмжихэд” чиглэсэн 3 шатаг хөдөлгөөн өрнүүлэхэд оршихоор төлөвлөжээ. Нэгдүгээр шатанд АПР-д итгэлцэлийн арга хэмжээг үүсгэн тогтооход тус дэм үзүүлэх, хоёрдугаар шатанд урьдчилан сэрэмжилсэн дипломатын механизмыг эмхлэн байгуулах, гуравдугаар шатанд сөргөлдөөнийг зохицуулах механизмыг эмхлэн байгуулах явдал байна гэж тодорхойлжээ.⁸

Эдүгээ АРФ-ын хүрээнд бүс нутгийн аюулгүй байдлын тухай асуудлаар олон талын яриа хэлцэл явагдаж байна. Форумын бүрэлдүүнд АСЕАН-ы 10 орон, Австрали, Энэтхэг, Канад, Хятад, Монгол, Шинэ Зеланд, Папуа-Шинэ Гвиней, Орос, АНУ, Өмнөд Солонгос, Япон зэрэг 11 улс, Европын холбоо оролцдог. Форум байгуулагдснаас хойш гадаад хэргийн сайд нарын түвшинд олон уулзалт

зохион байгуулсан бөгөөд сүүлийн үед бүс нутгийн аюулгүй байдлын хамгийн тулгамдсан хурц асуудлыг хэлэлцэх болсон байна. Сайд нар эдгээр асуудлыг илээр хэлэлцэж байгаа ганц энэ баримт нь ч Азийн улсуудын хооронд итгэлцэлийг бий болгон бэхжүүлэхэд нэн ач холбогдолтой бөгөөд энэ үйл явц цааш өрнөхийн суурь болно.

Монгол улс гадаад бодлогоо шинэчилж түүний тэргүүлэх чиглэлийг тогтооход Ази, Номхон далайн бүс нутаг чухал байр суурь эзлэх болж, бодлогын энэ чиглэл нь Ерөнхийлөгчийн мэдэгдлүүд, Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд тусгагдах болжээ. Энэ ерөнхий чиглэлийн дагуу манай улс, Ази, Номхон далайн бүс нутаг, түүний Зүүн хойд Азийн дэд бүс нутгийн орнуудтай хоёр талын худалдааны харилцааг өргөтгөн сүүлийн 10 жилд Хятад, Орос, Япон, АНУ, Өмнөд Солонгос зэрэг улс манай гол түнш орнууд болжээ. Энэ бүс нутагт манай улсын гол хандивлагч орнууд оршдог. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, Азийн хөгжлийн банкны гишүүний хувьд тэдэнтэй хамтын ажиллагаагаа өргөтгөсөн боловч бүс нутаг ба дэд бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллагын гадна оршсоор ирэв.

Өнгөрсөн зууны 90-ээд оны дундуураас манай улсын улс төрийн удирдлагын хүрээнээ энэ чиглэл дэх үйл ажиллагаа мэдэгдэм идэвхжиж, АПР-ийн интеграцийн байгууллагуудтай холбоо тогтоон, тэдний үйл ажиллагааг сонирхох болж, заримд нь гишүүн орон болон элсэх өргөдлөө гаргах боллоо. Холбогдох байгууллагууд, нэлээд орны удирдагчид Монголын хүсэлтэд нааштай хандаж байсан боловч дотооддоо тогтоосон журмаа ягштал баримталж, болзол нөхцлийг тайлбарлан ойлгуулж байв.

АПР-ийн олон талын хамтын ажиллагааны байгууллагууд дотроос Монголыг гишүүнээ болгох асуудлыг нааштай шийдсэн анхны байгууллага нь АСЕАН-ны бүсийн форум /АРФ/ юм. Уг форум 1998 оны 7-р сарын хурлаар Монголыг элсүүлэн авав. Дараа нь Монгол улс 2000 оны 4-р сард Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл /РЕКК/-ийн гишүүн болсон юм. Энэ журмын логик үргэлжлэл бол бүс нутгийн олон улсын эдийн засгийн байгууллагуудын системд хамгийн чухал “өндөрлөг” болж байгаа Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны /АПЕК/ форумд элсэх явдал юм. Манай улс элсэх өргөдлөө хэдийнэ өгсөн, эдүгээ түүнд элсэхийг хүссэн бусад 14 улсын хамт хэлэлцэх цагийг хүлээж буй. /Тус форумд шинэ гишүүн элсүүлэх асуудлыг хэлэлцэх хугацааг 10 жилээр хойшлуулсан шийдвэрийг АПЕК-аас 1997 онд гаргасан аж./

Харин АПЕК-ийн дүрэм ёсоор энэ байгууллагын гишүүн бүс улс форумын ажлын хэсгүүдийн удирдлагатай тохиролцсон үндсэн дээр

тэдгээрийн үйл ажиллагаанд хязгаардмал эрхтэйгээр оролцохыг зөвшөөрдөг. АПЕК-ийн 12 ажлын хэсгийн 4-д оролцох хүсэлт тавьж зөвшөөрүүлдэд 1994 оноос эхлэн эрчим хүч ба худалдааны хэсгүүдийн үйл ажиллагаанд оролцож байгаа юм. Манай гадаад эдийн засгийн холбогдох байгууллагууд Монгол улс АПЕК-т шинээр элсэх орнуудын шалгуурын нэг болсон тус форумтай хамтран ажиллах үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг боловсруулан засгийн газраар батлуулсан ажээ.

Монгол улс АПЕК-т элсвэл тодорхой үүргүүд өөртөө хүлээж авах ёстой, тухайлбал худалдаа ба хөрөнгө оруулалтыг либералчилах, Монголын зах зээлд нэвтрэн орох боломжийг өргөтгөх, шаардлагатай үед зайлшгүй техник-эдийн засгийн туслалцаа үзүүлэх гэх мэт. Тэгэхдээ энэ нь Монголын зах зээлийг ямар ч нөхцөл болзолгүйгээр нээнэ гэсэн үг хараахан биш. Иймэрхүү төрлийн асуудлуудыг тухайн үед сайн дурын үндсэн дээр консенсусын аргаар шийдэж байх нь ойлгомжтой. Бас тодорхой хэмжээний шахалт даралт ирнэ гэж хүлээх ч ёстой.

Манай улс Ази, Номхон далайн бүс нутгийн зарим бүтцэд оролцож байгаа байдал, цаашдаа гол бүтцэд оролцох төлвийг бодолцож анхаарах, бэлтгэх зүйлс байх бололтой. АПЕК-ийн нэлээд тогтворжсон, ятгүй салбарласан бүтцэд хэрхэн саадгүй нэвтрэн орох, форум дотор явуулах ажил хэрэгтээ стратегийн болон практикийн ямар шугам баримтлах, АПЕК-ийн гишүүний заавал ба сонголтоор гүйцэтгэх үүргийг хэрхэн биелүүлэх талаар бодож боловсруулах шаардлагатай мэт.

Ази, Номхон далайн чиглэлд явуулах бодлогоо нарийвчлах, тодотгох ажлыг судалгааны үнэлэлт, дүгнэлтэд суурилан хийх нь зайлшгүй. Үүний тул АПЕК-ийн интеграцийн үйл явцын аажим хувьсал, интеграцийн гол хөдөлгөгч хүчний асуудал, зохион байгуулалтын хэлбэр мэт олон чухал асуудлыг судлах хэрэгтэй. Өнөөгийн АПЕК-ийн дотор байгаа үүрэг хүлээлгэн хурдавчлан интегралчилах, эсвэл уян зөөлнөөр алгуур интегралчилах хоёр хандлагын алиныг баримтлахаа бодож сонгох зорилт тавигдана. Үүний хамт АПЕК дотор байнга харилцан үйлдэл хийж байх бодитой түнштэй болохын тул сонголт хийх, түншлэлийнхээ хүрээ хязгаарыг тодорхойлох явдал хэрэгтэй болно.

Олон жил өнгөрсний эцэст манай орон АПЕК-ийн интеграцийн үйл явцад идэвхтэй оролцох, тохиолдох бэрхшээлийг даван туулах бодит урьдач нөхцөл бүрэлдэж байна. Энэ нь Монголын төр засгийн шийдвэрлэх оролцолгоотой амжилттай урагшлах хөдөлгөөн болж манай эдийн засгийг шинэ өндөрлөг өөд хөтлөх болно.

ИШЛЭЛ, ЗҮҮЛГ

1. Проблемы Дальнего Востока, 1994, №1, с.13
2. Проблемы Дальнего Востока, 1999, №8, с.28-30
3. Россия и АТР, М., 2001, с.36
4. Россия и АТР, М., 2001, с.38
5. Проблемы Дальнего Востока, 1998, №1, с.29-31
6. Проблемы Дальнего Востока, 2001, №1, с.26-27
7. Отгонбаатар С. Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцийн үйл явц, түүнд Монголын оролцоо. Диссертацийн хураангуй. УБ., 2001
8. Россия и АТР, М., 2001, с.16-17